

“ТАВИЛГА” ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Тавилга ХК УБ:9010001050 Үнэт цаасны код: MN00TVL00410 Утасны дугаар: 99096416
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Түрээс
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	“Их наяд аудит” ХХК
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	122,754 (нэг зуун хорин хоёр мянга, долоон зуун тавин дөрөв) ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Жилийн тайланг бэлтгэсэн: Нягтлан бодогч: Д.Нарантунгалаг Хянасан: Гүйцэтгэх захирал Ц.Байгалмаа
1	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт
	Орлогын тайлан
	Мөнгөн гүйлгээний тайлан
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
Аудитын тайлан дүгнэлтийг хүргүүлсэн.	
1.2	Аудитын тодорхойлох захидал



“ТАВИЛГА” ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭШИГЧДЭД

ӨӨРЧӨЛӨТГҮЙ ДҮГНЭЛТ

Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу “ТАВИЛГА” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, амчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгуудад аудит хийлээ.

“ТАВИЛГА” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нэгтгэн бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангнаны олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тогтоотуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол улсын холбогдох хууль, журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийхдээ байгууллагаас хараат бус, аудиторын бс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний гүйцэтгүүлсэн хяналттай бөгөөд зохицот аудитын нотлоогоо нь дүгнэлт өгнө үндэслэл болно.

Асуудлыг өмчлөхөн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн ашиварл хяндуулах, өн холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд тогтоотуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нэгтгэн бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашд тус байгууллагын талаар чин үүрэг нь өргөргдөж татан буугдах, ногдах асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нэгдэл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайланг, нэгтгэн бодох бүртгэл, бүртгэлийн суурь, бодлогын өөрчлөлтөд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй болно.

Аудитыг гүйцэтгэхдээ аудитын хяварч үүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хяналттай, зохицот нотлоогоо олж авч боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотлоогоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход нүрэлгээтэй, зохицот гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хямаагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглал эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нэгтгэн бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангнаны олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогтоотуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залуулан эсвэл алдааны улмаас үүсэн материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхдээ шаардлагатай гэж үзсэн дотоод юанчлыг тодорхойлж, хэрэглүүлж үүрэг хариуцлага хүлээнэ.

Аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Аудитын байгууллага залуулан эсвэл алдааны улмаас үүсэн материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайланг бүхэлдээ ангиад эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшиндх боломж үнэмлэхүй түвшиний баталгаажуулалт бий бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрмөс илрүүлнэ гэсэн баталгаа бололгүй юм.

Буруу илэрхийлэл нь залуулан эсвэл алдаанаас үүсэн болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлнө үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ИХ НАЯД АУДИТ

БАХИРАЛ

Х АРИУНЗУЛ

Улаанбаатар хот Монгол улс

Огноо 2025 оны 02 сарын 24

2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлт/	
2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Манай компанийн харилцагч түрээслэгчдэд учирч байгаа валютын ханшийн өсөлт, бидний үйл ажиллагаанд сөрөг нөлөөллийг үзүүлсэн. Тус компанийн үл хөдлөх нь 1971 онд байгуулагдсан. Үйлдвэрийн барилгад засвар үйлчилгээ огт хийгдээгүй бөгөөд дээвэр муудаж ус алддаг, төвийн шугамтай холбогдоогүй учир түрээслэгч олоход хүндрэлтэй байсан.
2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл	Тайлант хугацаанд авсан зээл болон зээлийн баталгаа байхгүй.
3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.		
4	Цалин урамшууллын мэдээлэл:	
Тус компани нь 2024 онд Гүйцэтгэх удирдлага, 7-8 ажилчдад цалин хөлс, урамшууллыг олгосон болно.		
5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл:	
“Тавилга” ХК нь Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд багтдаг компани бөгөөд эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Бид компанийн үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржээс гаргасан холбогдох дүрэм, журмыг баримталж ажилладаг.		
6	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл:	
Манай компани нь агуулах түрээсийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд бидний үйл ажиллагаанд олон жил засвар үйлчилгээ хийгдээгүй үл хөдлөхийн хувьд дээврээс ус алдах мөн их хэмжээний бороо хур орсноос үүдэн цахилгааны гэмтэл, төр засгийн гэнэтийн шийдвэрүүд болон түрээслэгчдэд учрах валютын ханш, бараа материалын өсөлт, улс хоорондын тээвэр ложистик зэрэг асуудлууд нь голлох эрсдлүүдийг бий болгодог.		
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/	
Манай компани нь 2025 оны 04 сарын 07-ний бүртгэлийн өдрөөр нийт 122,754 ширхэг хувьцаа байсан. Компанийн 5 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч нь иргэн Э.Батхүү, Ц.Банзрагч, Ц.Баярмаа, Ц.Бат-Амгалан, Ч.Баясгалант, Ц.Байгалмаа, Ц.Баянмөнх нар тус тус эзэмшиж байна.		
8	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл	
Олон нийтэд шинээр санал болгон хувьцаа гаргаагүй болно.		
9	Ногдол ашгийн мэдээлэл:	
Тайлант хугацаанд ногдол ашиг тараагаагүй болно.		
10	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл	

Манай компани нь Хотоо хоггүй, цэвэр байлгах үүднээс улирал тутам байгууллагын их цэвэрлэгээ хийж, хашааны гадна болон дотор хог хаягдлыг цаг тухай бүрт хог ачилтын байгууллагатай гэрээлэн ачуулдаг.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Байгалмаа

Албан тушаал: Тавилга ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга, тэмдэг)



Мэдээлэл бэлтгэж, хургуулсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2025 оны 07-р сарын 03-ны өдөр

Овог, нэр: Х.Баяржаргал

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: ...Баяржаргал.....